



Japan
Fund for
Poverty
Reduction



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

С11- ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН СУУРЬ БОЛОН ЭЦСИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР ХҮРТЭЭМЖИД СУДАЛГАА ХИЙХ ЗӨВЛӨХ

А. ТАНИЛЦУУЛГА

Монгол улс, Азийн хөгжлийн банктай зээлийн гэрээ байгуулж (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхээр зөвшилцөлд хүрсэн. Тус төсөл нь Монгол Улсын Засгийн Газрыг дэмжин Улаанбаатар хот болон аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжиж үйлчилгээг сайжруулах зорилготой юм. Төслийн зорилго нь эдийн засаг болон нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даасан хувь нэмрийг оруулах зорилготой хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжийг хангах юм. Төслийн нарийн мэдээллийг доорх цахим хаягаар харна уу.

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төслийн үндсэн суурь үзүүлэлт, төслийн дуусах үеийн үзүүлэлт тооцох мэдээлэл цуглуулах, үзэгчдийн судалгааг цуглуулах ажлыг дотоодын судалгааны компаниар (Зөвлөх) гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна. ХНХЯ нь “Азийн Хөгжлийн Банк ба түүний зээлдэгч зөвлөхийг ашиглах журам”-д заасны дагуу дотоодын зөвлөх компанийг сонгон шалгаруулна.

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

1. Төслийн хэрэгжилтийг хянах тоон болон чанарын үзүүлэлтийг тодорхойлж төсөл хэрэгжиж эхлэх болон дуусах үеийн өөрчлөлтийг судлах, Үүнд:
 - ХБИ-д төрийн үйлчилгээнд хэр сэтгэл хангалуун байгааг, Үүнд: үйлчилгээний хүртээмж болон бэрхшээлүүд, хэрэгцээт тусламжийн түвшин болон туслах хэрэгслүүдийн ашиглалтын талаарх мэдээлэл багтана.
 - Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ХБИ-дэд ажил олгож ХБИ-дэд зориулсан бизнесийн орчныг бүрдүүлэх.
 - Мэдээлэл, дэд бүтэц, тээврийн хүртээмж хамарсан орчны хүртээмжийг сайжруулах.
2. ХБИ-ийн талаарх мэдлэг хандлагыг өөрчлөх телевиз радиогийн нэвтрүүлэг, сонин сэтгүүл, нийгмийн мэдээллийн сүлжээ, цахим хуудасны мэдээллийн хүртээмж, ач холбогдол, чанар, давтамж зэргийг төсөл хэрэгжих хугацаанд судалж, хянах юм.

В. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛУУД

Зорилтын хүрээнд:

Ерөнхий:

- Судалгааны арга зүй, түүврийн хэмжээ, асуулга, ярилцлага, багийн уулзалт болон шийдэл багтаасан судалгааны хэрэгсэл боловсруулж судалгааны нарийвчилсан цагийн хуваар гаргах, Үүнд: (i) ХБИ-ийн төрийн үйлчилгээнд хандах сэтгэл ханамжийн судалгаа, (ii) Компаниудын болон бизнесийн орчны талаарх судалгаа (iii) Мэдээлэл, дэд бүтэц, тээврийн хүртээмж хамарсан орчны хүртээмжийг сайжруулах талаар судлах, (iv) Хэвлэл мэдээллийн үзэгчдийн судалгаа;
- Судалгааны арга зүй, түүврийн хэмжээ, судалгааны хэрэгсэл болон судалгаа бүрийн цагийн хуваар гаргахдаа ТХН болон ХНХЯ-аас зөвшөөрөл авах;
- Хэрэв шаардлагатай бол Үнэлгээний хорооны гишүүдээс судалгаа хийх холбогдох зөвшөөрөл авах

Судалгаа бүрд:

- Хэрэв шаардлагатай бол судалгааны аргыг урьдчилан туршиж шаардлагатай засварыг хийх; Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцах харилцааны онцлог, ёс зүйд тодорхой анхаарал хандуулан мэдээлэл цуглуулах, судалгаанд оролцогчдоос асуулт асуух, бүлгийн хэлэлцүүлгийг хялбарчлах зорилготой судалгааны багт сургалт явуулах;
- Судалгааны хэрэгжилтийн явцын талаар ТХН-д байнга мэдэгдэх;
- Мэдээллийн дүн шинжилгээ хийх явцад шаардлагатай бол холбогдох талуудтай зөвлөлдөх хэлэлцүүлэг явуулж уулзалт зохион байгуулна.
- Судалгааны ажлын тайланг Монгол, Англи хэл дээр боловсруулж, ТХН, ХНХЯ-нд хянуулж, санал авах;
- Судалгаатай холбоотой мэдлэг түгээх ажлыг зохион байгуулж холбогдох семинар, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Тайланг боловсруулж, судалгааны ажлын тайланг цаг тухайд нь хүргэх.

Хэвлэл мэдээллийн үзэгчдийн судалгаа:

- Улирал тутам хүмүүсээс утсаар авах тоон судалгааны асуулгын дизайныг боловсруулж, асуулга явуулах. Санамсаргүй сонголтоор улсын хэмжээнд авсан ХБИ-тэй (гар утсаар холбогдох боломжтой) 150-200 хүнээс бүрдсэн түүврийн бүлгийг бий болгох (эсвэл асуулга авах бусад тохиромжтой хэрэгслийг хэрэглэх).
- ХБИ-тэй 30 удаагийн чанарын судалгааны зорилтот бүлгийн хэлэлцүүлгийг зохион байгуулах.

Г. НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

	Нийлүүлэх бүтээгдэхүүн
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн үйлчилгээнд хандах сэтгэл ханамжийн судалгаа
1	Суурь судалгааны тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
2	Судалгааны эцсийн үзүүлэлтийн тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн үйлчилгээнд хандах сэтгэл ханамжийн талаарх тайланг боловсруулах
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан компаниуд болон бизнесийн орчны талаарх судалгаа
4	Суурь судалгааны тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
5	Судалгааны эцсийн үзүүлэлтийн тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан компаниуд болон бизнесийн орчны талаарх тайлан бэлдэх
	Мэдээлэл, дэд бүтэц, тээврийн хүртээмж хамарсан орчны хүртээмжийг сайжруулах талаар судлах.

7	Суурь судалгааны тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
8	Судалгааны эцсийн үзүүлэлтийн тайлан, Төслийн дизайн, хяналтын хүрээтэй уялдуулсан байх
9	Мэдээлэл, дэд бүтэц, тээврийн хүртээмж хамарсан орчны хүртээмжийг сайжруулах талаар тайлан бэлдэх
Хэвлэл мэдээллийн үзэгчдийн судалгаа	
10	Утасны тоон судалгааны улирлын тайлан (эсвэл өөр холбогдох хэрэгслийг ашиглах)
11	Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнг багтаасан жилийн тайлан
12	Тоон болон чанарын судалгааны тайланг боловсруулах

Д. ТАЙЛАГНАЛЫН ШААРДЛАГА

i) ХНХЯ тай урьдчилан тохиролцсон формат болон процессын дагуу зөвлөх үйлчилгээний байгууллага нь үр дүнгээ тайлагнаж шинэчилнэ.

(ii) Зөвлөх үйлчилгээний фирм нь ХНХЯ-д зөвлөгөө үзүүлэх болон үндсэн оролцогчидтой зөвшилцөхөд дэмжлэг үзүүлнэ. Зөвлөх үйлчилгээний фирм нь холбогдох агентлаг болон оролцогч талуудаас ирсэн санал дээр үндэслэсэн баримтуудыг эцэслэх болон хянах үүрэгтэй. Техникийн тайлан нь техникийн ажлын хэсэг болон бусад холбоотой оролцогч талуудын уулзалт дээр шаардлагатай гэвэл танилцуулагдаж болно.

(iii) Бүх тайланг 2 хэл дээр бэлтгэсэн байх шаардлагатай / Монгол болон Англи /